# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН II ХУРАЛДААНЫ ДОТООД ТОВЪЁОГ

2012.12.17 Шарга

| № | Хуралдааны материал | Хуудасны дугаар |
|---|---|---|
| 1 | Хуралдааны мэдээ | 1 |
| 2 | Хуралдаан зарласан Тэргүүлэгчдийн тогтоол | 2-3 |
| 3 | Хуралдааныг нээж хэлсэн | 4 |
| 4 | Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө | 5 |
| 5 | Хуралдааны дотоод журам | 6 |
| 6 | Төлөөлөгчдийн ирцийн бүртгэл | 7 |
| 7 | Хуралдаанаас гарсан тогтоолууд | 8-22 |
| 10 | Сумын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл | 23-29 |
| 11 | Сумын Засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөрийн биелэлт, 2013-2016 оны мөрийн хөтөлбөр | 30-41 |
| 12 | Сумын 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн төсөл, хуваарийг батлах | 42-53 |
| 13 | Хуралдааны тэмдэглэл | 54-77 |

**Материал эмхэтгэсэн:**

ИТХТ-ийн нарийн бичгийн дарга......................................../Д.Цэцэгмаа/

# Цагаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II хуралдааны мэдээ

2012.12.17 Шарга

| Д/Д | Асуулт | Тэмдэглэл |
|---|---|---|
| 1 | Хуралдааны дугаар | I |
| 2 | Хурал зарласан он, сар, өдөр | 2012.12.10 |
| 3 | Хуралдсан он, сар, өдөр | 2012.12.17 |
| 4 | Бүх төлөөлөгч | 27 |
| 5 | Хуралд оролцсон | 23 |
| | Өвчтэй | 1 |
| | Чөлөөтэй | 1 |
| | Ажилтай | - |
| | Өөр шалтгаантай | 2 |
| 6 | Ирцийн хувь | 88.8 |
| 7 | Хэлэлцсэн асуудлын тоо | 9 |
| 8 | Үг хэлсэн хүний тоо | 12 |
| 9 | Үүнээс төлөөлөгч | 8 |
| 10 | Гаргасан тоо тогтоолын дугаар | 4 |
| | | 1 *Хурлын хороо байгуулах, ажиллах журмыг батлах* |
| | | 2 *Цагаан-Уул сумын нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай* |
| | | 3 *2013 оны төсөв батлах тухай* |
| | | 4 *Төсөв батлах тухай* |

Хуралдаан зарлах, хэлэлцэх
асуудал товлох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай Хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II хуралдааныг 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн $10^{00}$ цагт Соёлын төвд хуралдуулсугай.

**Хоёр.** Тус хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.
Үүнд:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013-2014 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл
2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо байгуулж батлах
3. Сумын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
4. Сумын Засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөрийн биелэлт, 2013-2016 оны мөрийн хөтөлбөр
5. Сумын 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн төсөл, хуваарийг батлах
6. Сумын 2012 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2013 оны төлөвлөгөөг батлах
7. Сум орон нутгийн өвөлжилтийн байдал, цаашид зохион байгуулах асуудал
8. Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн ажлын тайлан, 2013 онд хийх ажлын төлөвлөгөө
9. "Галт дулаан" ОНӨААТҮГ-ын ажлын тайлан болон санхүүгийн тайланг хэлэлцэх

**Гурав.** Хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

**Дөрөв.** Хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааны зар хүргэх ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Дарамжав/, нарийн бичгийн дарга /Д.Цэцэгмаа/ нарт үүрэг болгосугай.

**ДАРГА** **Ч.АЗБАЯР**

# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН II ХУРАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2012.12.07 Шарга

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013-2016 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл
2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо байгуулж батлах
3. Сумын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
4. Сумын Засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөрийн биелэлт, 2013-2016 оны мөрийн хөтөлбөр
5. Сумын 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн төсөл, хуваарийг батлах
6. Сумын 2012 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2013 оны төлөвлөгөөг батлах
7. Сум орон нутгийн өвөлжилтийн байдал, цаашид зохион байгуулах асуудал
8. Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн ажлын тайлан, 2013 онд хийх ажлын төлөвлөгөө
9. “Галт дулаан” ОНӨААТҮГ-ын ажлын тайлан болон санхүүгийн тайланг хэлэлцэх
10. Цагаан-Уул сумын 6-р багийн иргэн Х.Лхамсүрэнгийн “Гэр” төсөлд хамруулах тухай өргөдлийг хэлэлцэх

# Цагаан-Уул сумын ИТХ-ын II хуралдааны дотоод журам

**2012.12.17** **Шарга**

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013-2014 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл

    Илтгэгч Ч.Азбаяр /20 минут/

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороог байгуулж батлах

    Илтгэгч Ч.Азбаяр /20 минут/

3. Сумын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

    Илтгэгч Б.Дорждагва /10 минут/

4. Сумын Засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөрийн биелэлт, 2013-2016 оны мөрийн хөтөлбөр

    Илтгэгч Д.Түмэнбаяр /20 минут/

5. Сумын 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн төсөл, хуваарийг батлах

    Илтгэгч Төрийн сангийн төлөөлөгч Ш.Эрдэнэцэцэг /30 минут/

6. Сумын 2012 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2013 оны төлөвлөгөөг батлах

    Илтгэгч Газрын даамал А.Энхбаатар /10 минут/

7. Сум орон нутгийн өвөлжилтийн байдал, цаашид зохион байгуулах асуудал

    Б.Дорждагва /10 минут/

8. Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн ажлын тайлан, 2013 онд хийх ажлын төлөвлөгөө

    Илтгэгч Б.Дорждагва /5 минут/ Н.Хэнмэдэх /5 минут/

9. "Галт дулаан" ОНӨААТҮГ-ын ажлын тайлан болон санхүүгийн тайланг хэлэлцэх Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн ажлын тайлан, 2013 онд хийх ажлын төлөвлөгөө

    Илтгэгч Л.Галтбаатар, Г.Оюунчимэг /15 минут

10. Цагаан-Уул сумын 6-р багийн иргэн Х.Лхамсүрэнгийн өргөдлийг хэлэлцэх

ИТХ-ын хуралдаанд оролцогчид хэлэлцэх асуудалтай холбогдолтой асуулт асууж болно. Асуултанд цаг тогтоохгүй.

Санал шүүмжлэлийг асуудал тус бүр дээр гаргах буюу эхний удаа 7 минут, дараагийн удаа 5 минут байна.

Хуралдааныг $10^{00}$ минутад эхэлж, 2 цаг тутамд 10 минут завсарлаж, $13^{00}$ - $14^{00}$ цагийн хооронд үдийн хоолонд оруулан өдөрт нь багтаан явуулна.

# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИРЦИЙН БҮРТГЭЛ

2012.12.17 Шарга

| № | Төлөөлөгчдийн нэрс | ИТХ-ын II хуралдаанд оролцсон байдал |
|---|---|---|
| 1 | Ж.Бумцэнд | Ирсэн |
| 2 | Ч.Азбаяр | Ирсэн |
| 3 | О.Шадав | Ирсэн |
| 4 | Д.Мягмар | Ирсэн |
| 5 | Н.Алтанбаатар | Ирсэн |
| 6 | А.Ням-Очир | Ирсэн |
| 7 | Д.Түмэнбаяр | Ирсэн |
| 8 | Л.Баттулга | Ирсэн |
| 9 | Г.Сүхбаатар | Ирсэн |
| 10 | Л.Баатарчулуун | Тасалсан |
| 11 | М.Сономванчиг | Чөлөөтэй |
| 12 | Б.Жамбалсүрэн | Ирсэн |
| 13 | Д.Нямдорж | Ирсэн |
| 14 | Х.Батзаяа | Ирсэн |
| 15 | Чи.Өнөржаргал | Ирсэн |
| 16 | Х.Даваасүрэн | Ирсэн |
| 17 | Д.Мөнх-Очир | Ирсэн |
| 18 | В.Баасанрагчаа | Ирсэн |
| 19 | Ч.Өнөржаргал | Ирсэн |
| 20 | Б.Баасанчулуун | Ирсэн |
| 21 | А.Одонбаяр | Ирсэн |
| 22 | Ц.Эрдэнэчимэг | Ирсэн |
| 23 | Ц.Ренчинмядаг | Чөлөөтэй |
| 24 | М.Мөнхбаатар | Ирсэн |
| 25 | Г.Далхсүрэн | Тасалсан |
| 26 | Ж.Шижирбаатар | Ирсэн |
| 27 | Б.Алтаншагай | Ирсэн |

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
# ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 12 сарын 17 өдөр Дугаар 01 Шарга

Хурлын хороо байгуулах, ажиллах
журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай хуулийн 18.1 /в/, 21.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар батлсугай_.

**Хоёр.** Хорооны ажиллах журмыг мөрдөж ажлын төлөвлөгөө гарган ажиллахыг хороодын дарга, нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

**ДАРГА** **Ч.АЗБАЯР**

# ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ-ЫН САЛБАР ХАРИУЦСАН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Сумын ИТХ нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын тогтоол шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий дараах Хороодыг байгуулан ажиллуулж , хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангана.

1. **Хуулийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам, мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан хороо**

Ч.Азбаяр
Д.Түмэнбаяр
Д.Мөнх-Очир
М.Сономванчиг
Чи.Өнөржаргал

2. **ХХАА, ЖДҮ,төсөл хариуцсан хороо**

Б.Алтаншагай
М.Мөнхбаатар
А.Одонбаяр
А.Ням-Очир
Б.Жамбалсүрэн

**3.Эрүүл мэнд, соёл, боловсрол хариуцсан хороо**

Ча.Өнөржаргал
Ц.Эрдэнэчимэг
Л.Баттулга
Х.Даваасүрэн
Л.Баатарчулуун

4. **Эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан хороо**

Д.Түмэнбаяр
Ч.Азбаяр
Х.Батзаяа
Г.Сүхбаатар
Д.Мягмар

5. **Байгаль орчин , газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хороо**

Б.Баасанчулуун
Ж.Бумцэнд
Д.Мягмар
Д.Нямдорж
Г.Далхсүрэн

6. **Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй харилцах асуудал хариуцсан хороо.**

Чи.Өнөржаргал
В.Баасанрагчаа
Н.Алтанбаатар
Ц.Ренчинмядаг
О.Шадав

7. **Ес зүй, хяналт шалгалтын хороо.**

Ча.Өнөржаргал
Ж.Шижирбаатар
М.Сономванчиг
Л.Баттулга
А.Ням-Очир

# ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ-ЫН САЛБАР ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

## НЭГ.НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ.

1. Сумын ИТХ-ын салбар хороод нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын тогтоол шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэгтэйгээр хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангана.

2. Хороог хурлын бүрэн эрхийн хугацаагаар Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн Хорооны хурлаар Төлөөлөгчдийн дотроос сонгоно.

3. Хороо нь ИТХ-ын хуралдаанд асуудал санаачлан хэлэлцүүлэхээр оруулах эрх, үүрэгтэй.

4. Төрийн болон ТББ, аж ахуйн нэгж, иргэдээс ИТХ-ын хуралдаан болон Тэргүүлэгчдэд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачилбал түүнийг хүлээн авч судалж боловсруулах, гарах шийдвэрийн төсөлд чиглэл өгч, дэмжлэг үзүүлнэ.

5. Шаардлагатай гэж үзсэн зарим асуудлаар Хороод нь хамтарсан үйл ажиллагаа явуулж болно.

6. Хариуцсан чиглэлээр иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдол эрэлт хэрэгцээг байнга судалж нэгтгэн , дүгнэлт гаргаж Тэргүүлэгчдэд хагас бүтэн жилээр мэдээлэл хийнэ.

7. Хариуцсан салбар дахь ИТХ-ын хяналт, шалгалтын ажлыг хариуцан гүйцэтгэж дүнг хуралд болон иргэдэд мэдээлнэ.

## ХОЁР. САЛБАР ХОРООДЫН ЧИГ ҮҮРЭГ.

1. **Хуулийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам, мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан хороо**

1.1 Хууль тогтоомж хурлын бодлого шийдвэрийг иргэдэд хүргэж, тайлбарлан таниулах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай гэж үзсэн тодорхой асуудлаар бодлого боловсруулж хяналт тавих.

1.2 Нийгмийн дэг журам, хууль сахиулах болон хяналтын байгууллага, албан тушаалтантай холбогдсон санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч судлан шийдвэрлэж, хуралд мэдээлэх

1.3 Нутаг дэвсгэрийн хэмжээнд сахилга дэг журмыг бэхжүүлэх , Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулж иргэдийн идэвхи оролцоог хангаж байгааг хянан шалгаж туслах, иргэдээс төрийн байгууллага , албан тушаалтанд хандсан өргөдөл санал хүсэлт, гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавьж , шалган туслах

1.4 Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр нь хууль, хурлын шийдвэр, иргэдийн эрх ашигт харшилж байвал хүчингүй болгох шийдвэр гаргуулах арга хэмжээг шуурхай авч мэдээлэх

1.5 Иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт сурталчилгаа явуулах , нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх, хамгаалалт зохион байгуулалтын бэлэн байдалд хяналт тавьж шийдвэрлүүлэх

## 2. ХХАА, ЖДҮ,төсөл хариуцсан хороо

2.1 Хөдөө аж ахуйн, үйлдвэрлэл үйлчилгээний газар, бэлчээрийг зүй зохистой төлөвлөх, ашиглах талаар судалж боловсруулан хуралд оруулах, хурлын шийдвэрийн биелэлтэнд хяналт шалгалт, үнэлгээ дүгнэлт өгөх

2.2 Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг үржлийн ажлыг зохион байгуулах , байгалийн гэнэтийн аюул мал амьтан ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд тавих хяналт, үнэлгээ, дэг журам, мэргэжлийн байгууллагын үүрэг оролцоо, хийгдэж буй ажлын чанарт хяналт тавьж үнэлгээ өгөх

2.3 Нутгийн шилмэл омгийн мал удмын санг хамгаалах, өсгөж үржүүлэх, нутагшуулахад иргэдийн санал туршлага идэвх санаачлагад тулгуурлан авах арга хэмжээг зохион байгуулах, бодлого боловсруулж, хяналт тавих

2.4 Орон нутагт ажиллаж байгаа жижиг дунд үйлдвэрийг дэмжих, технологи шинэчлэх цаашид өргөжүүлэх бодлогыг боловсруулах, өрхийн бичил үйлдвэрлэл ажлын арга туршлагыг дэмжиж туслах ажлыг судалж боловсруулах

## 3. Эрүүл мэнд, соёл, боловсрол хариуцсан хороо

3.1 Боловсрол, соёл , эрүүл мэнд , биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого , хууль тогтоомж, хурлын шийдвэрийн биелэлт, явцад хяналт судалгаа дүгнэлт хийж, авах арга хэмжээг боловсруулж шийдвэрлүүлэх

3.2 Ариун цэвэр , халдваргүйжүүлэлтийн байдалд үнэлгээ өгч, хүн амыг гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх , вакцинжуулалт, бэлэн байдалд хяналт тавьж авах арга хэмжээг боловсруулж шийдвэрлүүлэх

3.3 Нутаг дэвсгэр дэх түүхийн дурсгалт зүйлийн бүртгэл судалгааг зураг, бичлэгт бэхжүүлэх, хамгаалах, сэргээн засварлах, зохистой ашиглалтыг судалж шийдвэрлүүлэх

3.4 Урлаг спорт, шинжлэх ухааны онцгой амжилт гаргасан нутгийн иргэдийг алдаршуулах , урамшуулах , дэмжиж хөгжүүлэх журам боловсруулж шийдвэрлүүлэх

3.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд үнэлгээ өгч, иргэд үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг судалж авах арга хэмжээг боловсруулан шийдвэрлүүлэх

## 4. Эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан хороо

4.1 Хуульд заасан хязгаар шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр хураамжийг судалж, шинээр бий болгох орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломж , нөхцөлийг судалж хуралд оруулах

4.2 Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн, эд хөрөнгө хувьцаа, орон нутгийн төсвийн бодлого , хөрөнгө бэлтгэл нөөц бусад үл хөдлөх болон , хөдлөх эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, зарцуулалт, түүний журамд хяналт тавьж дүгнэлт гаргах

4.3 Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын болон , хэтийн үндсэн чиглэл, хувьчилж болох, болохгүй өмчийг судалж, дүгнэлтийг хуралд оруулах

4.4 Сумын төвийн эрчим хүчний хангамж үртээмжийг сайжруулах , худалдаа, ахуй үйлчилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрсөн цэг байгуулах боломжийг судалж бодлого боловсруулж хэрэгжүүлэх

4.5 Орон нутагт тулгамдаж буй асуудлаар судалгаа явуулж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон төсөл, хөтөлбөр, бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

## 5. Байгаль орчин , газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хороо

5.1 Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз , байгаль орчин хүн ам, мал амьтанд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох хүсэлт Засаг даргын санал үндэслэлийг сайтар судалж, санал дүгнэлтээ хуралд оруулах, стратегийн ач холбогдолтой байгалийн цогцолборт газрыг тодорхойлж тусгай хамгаалалтанд авах санаачлага гаргах

5.2 Ойн нөхөн сэргэлтийг хангах, хэрэглээний болон түлшний моды хэрэглээг багасгах, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхүүдийн бодит хэрэлээнд хяналт тавих, ойн нөхөрлөлийг дэмжих бодлогыг боловсруулах

5.3 Хөрс бэлчээр, мод ургамал, амьтан , рашаан, булаг усны эх ундаргыг амгаалах , зохистой ашиглах талаар бодлого боловсруулах

5.4 Ажил олгогч , хөдөлмөр эрхлэгчдийн хоорондох хууль эрх зүйн орчинд анхаарал тавьж цалин хөлс олголт, хөдөлмөрийн гэрээ , хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлийн стандарт, нийгмийн даатгалд хамруулах шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавих

5.5 Аж ахуйгаа хөгжүүлж ажлын байр бий болгож байгаа иргэд айл өрх, аж ахуйн нэгж, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг баг бүрээр шалгаруулж урамшуулах бодлого боловсруулж батлуулах

5.6 Нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг үр дүнд хүргэх, ажлын байр бий болгож бүтээмжийн өсөлтийг хангах бодлого, арга хэмжээг боловсруулж шийдвэрлүүлэх

## 6. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй харилцах асуудал хариуцсан хороо.

6.1 Хууль тогтоомж, засгийн газар, хурлын шийдвэрийг сурталчилах, хэрэгжилтийг зохион байгуулах ажлын арга, хамрах хүрээ, үр дүнд хяналт тавьж сайжруулах санал арга хэмжээг судлаж , боловсруулж хэрэгжүүлэх

6.2 Иргэдийг хүлээн авах тэдний санал , өргөдөл, гомдол , санаачлага, хүсэлтийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авахуулах

6.3 Орон нутагт үйл ажиллаж буй төрийн бус байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх бодлого боловсруулж хуралд оруулах

6.4 Засаг дарга, түүний ажлын албадын үйл ажиллагаанд өгөх иргэдийн үнэлгээг судалж, тэдгээрийн ил тод нээлттэй, шударга, шуурхай чиргэдэлгүй үйлчилгээнд үнэлэлт өгөх, иргэдийн үнэлэлт санал шүүмжлэлийн мөрөөр тодорхой шийдвэр гаргуулж хэрэгжүүлэх

6.5 Хүн амыг ажилгүйдэл, ядуурлаас хамгаалах, түүнтэй тэмцэх асуудлаар гаргасан хууль тогтоомж, төсөл хөтөлбөрүүдийн явц, хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж өгөөж, үр дүнг тооцон сонгогч иргэдэд мэдээлэх

6.6 Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэжил дадлага туршлага, ур чадвар, харилцааны соёл, өсч чадваржиж байгаа байдалд иргэдийн үнэлгээ дүгнэлттэй уялдуулан хяналт тавьж дадлагажуулах, мэргэшүүлэх талаар бодлого боловсруулж ажиллах

## 7 Ес зүй хяналт шалгалтын хороо.

7.1 Төсөв, төсөл хөтөлбөр, тендрийн удирдлага, зохион байгуулалт, шударга байдал, гүйцэтгэсэн ажлын чанар, хөрөнгийн зарцуулалтанд аудит, хяналтыг бүх шатанд нь хийж мэдээлэх

7.2 Байгалийн гамшиг тохиолдсон үед хүн мал, эд хөрөнгийг аврах , нүүлгэн шилжүүлэх, тусламж үзүүлэх, гэнтийн ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөө, бэлтгэл, бэлэн байдалд хяналт шалгалт хийж авах арга хэмжээг боловсруулж хангуулах

7.3 Орон нутагт үйл ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа иргэдийн эрх ашиг, байгаль орчинд хохирол учруулахуйц зөрчилтэй эсхэд хяналт тавьж шаардлагатай гэж үзвэл холбогдох хуулийн дагуу хуралд асуудал оруулж шийдвэрлүүлэх

7.4

**ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ-ЫН**
**АЖЛЫН АЛБА**

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
# ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 12 сарын 17 өдөр Дугаар 02 Шарга

Цагаан-Уул сумын нийгэм, эдийн засгийг
2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай Хуулийн 18-р зүйлийн 18.1.2 /а/ дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** Сумын нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

**Хоёр.** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас гарсан санал дүгнэлтийг сумын нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусган ажиллахыг сумын Засаг дарга /Д.Түмэнбаяр/-д даалгасугай.

**ДАРГА** **Ч.АЗБАЯР**

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
# ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 12 сарын 17 өдөр Дугаар 03 Шарга

2013 оны төсөв батлах тухай

Төсвийн тухай хуулийн 64.1.2 дахь заалт, Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалт, Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ нь:**

**Нэг.** Цагаан-Уул сумын 2013 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| | **Сумын төсвийн орлого бүгд** | |
| 1 | **Урсгал орлого** | 62095,0 |
| 1.1. | **Сумын төсвийн татварын орлого** | 52945.0 |
| 1.1.1 | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар | 15250.0 |
| 1.1.2 | орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар | 520.0 |
| 1.1.3 | бууны албан татвар | 1380.0 |
| 1.1.4 | нохойны албан татвар | 1000.0 |
| 1.1.5 | Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж | 5900.0 |
| 1.1.6 | ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж | 510.0 |
| 1.1.7 | түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | |
| 1.1.8 | байгалийн ургамал ашигласны төлбөр | 900.0 |
| 1.1.9 | хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр | 500.0 |
| 1.1.10 | ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр | 26655.0 |
| 1.1.11 | агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж | 330.0 |
| 1.2. | **Сум/дүүргийн төсвийн татварын бус орлого** | 8150.0 |
| 1.2.1 | орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг | |
| 1.2.2 | орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр | |

| | | |
|---|---|---|
| 1.2.3 | хүү, торгуулийн орлого | 8150.0 |
| 1.2.4 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | |
| 1.2.5 | хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого. | |
| 1.2.6 | Өмч хувьчлалын орлого | |
| 2. | **Хөрөнгийн орлого** | 1000.0 |
| 2.1 | Хөрөнгө борлуулсны орлого | 1000.0 |
| 3. | **Тусламжийн орлого** | |
| 3.1 | Хандив тусламжийн орлого | |
| 3.2 | Санхүүгийн дэмжлэг | |
| 3.3 | Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг | |
| 3.4 | Тусгай зориулалтын шилжүүлэг | |

**Хоёр.** Цагаан-Уул сумын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| **2.1.** | **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга** | |
| 2.1.1 | Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого | |
| **2.2.** | **Засаг дарга** | |
| 2.2.1. | Харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлого | |
| **2.2.2.** | Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого | |
| **2.3.** | **Сургуулийн захирал/Цэцэрлэгийн эрхлэгч** | |
| 2.3.1 | Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого | |
| **2.4.** | **Соёлын төвийн эрхлэгч** | 1000,0 |
| 2.4.1 | Харьяалах төсөвт байгууллагын төсөвт | 1000,0 |

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт /дүн/ | 62095,0 |
|---|---|---|
| 1 | Орон нутгийн орлогоос | 62095,0 |
| | | |
| | | |
| | | |

**Гурав.** Сумын 2013 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурьдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай.

/мянган төгрөг/

| № | | Нийт зарлага | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Санхүү дэмжлэг | Сумын орлогоос | Аймгийн орлого | Урд оны төсвийн хэмнэлтээс | Лицензийн орлогоос |
| 1 | Сумын ИТХ | 43804,4 | | | 43.363.2 | 441,2 | |
| 2 | Сумын ЗДТГ Үүнээс: | 239281.1 | 35060,9 | 62095,0 | 115000,0 | 27125.2 | |
| | Урсгал зардалд | 239281.1 | | | | | |
| | Хөрөнгийн зардалд | | | | | | |
| 3 | Багийн Засаг дарга | 78519,9 | | | 68330,0 | 10189,9 | |
| 4 | **Халамжийн сан** | **554660,0** | **554660,0** | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Үүнээс:** | | | | | | |
| Халамжийн тэтгэвэр | 229200,0 | 229200,0 | | | | |
| Жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж | 93400,0 | 93400,0 | | | | |
| Халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээ | 60,0 | 60,0 | | | | |
| Нөхцөлт мөнгөн тусламж | 54500,0 | 54500,0 | | | | |
| Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 19000,0 | 19000,0 | | | | |
| Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж | 38000,0 | 38000,0 | | | | |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ | 20000,0 | 20000,0 | | | | |
| Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт | 65000,0 | 65000,0 | | | | |
| Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг | 35000,0 | 35000,0 | | | | |
| Банкны үйлчилгээний хураамж | 500,0 | 500,0 | | | | |
| Ажил олгогчоос олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | | | | |

**Дөрөв.** Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/мянган төгрөг/

| | | |
|---|---|---|
| 4.1. | СӨБ | 65412.5 |
| 4.2 | ЕББДСургууль | 1100312.8 |
| 4.3 | Соёлын төв | 65997.5 |
| | Дүн | 1231722.8 |

**Тав.** Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 106850,0 мянган төгрөгөөр баталсугай.

**Зургаа.** Урьд оны үлдэгдлээс санхүүжих урсгал зардлын дүнг 37756.3 мян төгрөгөөр баталсугай.

**Долоо.** Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

**Найм.** Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 2,3 дугаар хавсралт ёсоор баталсугай.

**Ес.** Төсөвтэй холбоотой бусад заалт

**ДАРГА** **Ч.АЗБАЯР**

Цагаан-Уул сумын ИТХ-ын ээлжит II хуралдааны
2012 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

**ДАВСАН ОРЛОГООС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ, ТӨСӨВ**

| № | Үйл ажиллагаа, Зардлын утга | Зардал /мян:төг/ |
|---|---|---|
| 1 | Байгалийн эрсдлийн санд төвлөрүүлэх | 3000.0 |
| 2 | Аймгийн аварга шалгаруулах спортын тэмцээн суманд зохион байгуулах | 1000.0 |
| 3 | Баруун бүсийн Хүүхдийн чуулган зохион байгуулах | 1500.0 |
| 4 | ЗДТГ-ын машины дугуй авахад зарцуулах | 1000.0 |
| 5 | Мал эмнэлэгийн машинд олгой хаймер авах | 200.0 |
| 6 | Малын гоц халдварт өвчинд | 1000.0 |
| 7 | Сар шинийн баярыг тохиолдуулан ахмадад хүндэтгэл үзүүлэх | 500.0 |
| 8 | Агар хилийн заставтай хамтран ажиллах | 500.0 |
| 9 | Багийн хүний эмч нарын хөдөө багтаа ажиллахад шатахууны дэмжлэг үзүүлэх | 1000.0 |
| 10 | Сумын ахмадын холбооны үйл ажиллагааг дэмжих | 500.0 |
| 11 | Улаанбаатар дах Нутгийн зөвлөлийн золголтонд зарцуулах | 1000.0 |
| 12 | Бусад зардал | 1800.0 |
| | Нийт | 13000.0 |

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
# ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 12 сарын 17 өдөр Дугаар 04 Шарга

Төсөв батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4, сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, санхүүжилтийн хуваарийг хавсралтаар баталсугай.

**Хоёр.** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэл, зарцуулалтанд олон нийтийн хяналт тавих боломжийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Түмэнбаяр/, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**Гурав.** Батлагдсан төсвийн гүйцэтгэл, зарцуулалтанд хяналт тавин , хийгдсэн ажлын тайланг улирал тутамд олон нийтэд мэдээлж, хууль, журмын дагуу ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч /Д.Түмэнбаяр/-д даалгасугай.

**ДАРГА** **Ч.АЗБАЯР**

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн .........тоот тогтоолын хавсралт

# Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалт

1. Хайрган зам сайжруулах, ус зайлуулах хоолой – 30,0 сая төгрөг
2. Малын эмчилгээний хашаа барих /Өвгөд, Агар, Шарга, Тосон / - 20.0 сая төгрөг
3. Хуримтын хөндийд ногоон тэжээл тариалах – 21.7 сая төгрөг
4. Тосон багт эрчим хүч оруулах – 51.0 сая төгрөг
5. Хадлангийн талбай хаших / Өвгөд, Агар, Шарга, Тосон / – 12.0 сая төгрөг
6. Их Элээт, Бага Элээтийн зам, гүүр засах - 8.0 сая төгрөг
7. Улсын баяр наадамд – 8.5 сая төгрөг
8. Шахмал түлшний үйлдвэр байгуулах – 25.0 сая төгрөг
9. Халуун усны байр шинээр барих – 40.0 сая төгрөг
10. Сумын төвийг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж – 5.0 сая төгрөг
11. Байгалийн нөхөн сэргээлтэнд /20 га талбай/ - 4.0 сая төгрөг
12. Сумын төвийн хог хаягдлын цэгийг хаших – 5.0 сая төгрөг
13. Бой, нядалгааны цэг – 5.0 сая төгрөг
14. Малжуулах /Хөдөөгийн 5 багт/ - 10.0 сая төгрөг
15. Бусад – 11.7 сая төгрөг

# ЦАГААН-УУЛ СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙГ 2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ, 2013 ОНД СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ:

2012 оны 12-р сарын 17

**Төлөөлөгч нөхдөө :**

Ээлжит орон нутгийн сонгуулийн үр дүнд иргэдийнхээ олонхын санал авч ИТХ-ийн төлөөлөгч болсон та нөхдөд болон хуралд урилгаар оролцож байгаа хүмүүст энэ өдрийн мэнд хүргэе.

Өнгөрсөн 2012 он маань манай улс орны хувьд УИХ-ын болон Аймаг, дүүрэг, сумын ИТХ-г сонгох ээлжит сонгуулийн жил байсан нь хамгийн их хариуцлагатай байхыг шаардсан юм. Сумын хэмжээнд УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуулийг амжилттай зохион байгуулан явууллаа. Үүний үр дүнд сум орныг дараагийн 4-н жилд удирдан зохион байгуулж ажиллах шинэ төлөөллийг сонгож чадлаа. Энэ удаад шинээр сонгогдсон ИТХ-ийн төлөөлөгчдөд санхүүгийн хувьд нэлээд хэмжээний чөлөөт үлдэгдэлтэйгээр: Тухайлбал: Орон нутгийн төсөвт байгууллагууд болон сангуудын үлдэгдэл 189 сая төгрөг, бусад төсөвт байгууллагуудын хэмнэсэн төсөв 83,3 сая нийт 272,3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөтэйгээр хүлээлгэн өглөө.

Энэ нь 2013 онд сум орны нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болно гэдэгт итгэл дүүрэн байна. 2012 онд зуншлага харьцангуй сайн байснаас гадна 2010 оноос 2011 оны өвөлжилт тааламжтай болсноос малын хорогдол бага байлаа. Үүний үр дүнд сумын малын тоо толгой урьдчилсан байдлаар өмнөх оныхоос

Ингээд та бүхэнд малын тоог 5-н төрлөөр танилцуулья: Үүнд

| Д/д | Малын төрөл | 2011 он | 2012 он | Өсөлт /+/ Бууралт /-/ |
|---|---|---|---|---|
| 1 | Тэмээ | 666 | 626 | -40 |
| 2 | Адуу | 13029 | 13421 | +392 |
| 3 | Үхэр | 12124 | 13188 | +1064 |
| 4 | Хонь | 133394 | 149305 | +15911 |
| 5 | Ямаа | 97221 | 100688 | +3467 |
| | Дүн | 256434 | 277228 | +20794 |

байна.

# цагаан-уул сумын 2012 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

| № | Хийгдэх ажлууд | Хугацаа | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Спорт. урлагийн цогцолбортой болох | 2012 | Санхүүжилтын эх үүсвэр олдоогүй |
| 2 | Байгууллага бүр гадна орчноо тохижуулж мод бут тарих | 2012 | Сумын хэмжээнд 200 гаруй мод тарисан |
| 3 | Сумын төв талбай болон цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг улам сайжруулах | 2012 | Хөшөөнүүдийг засварласан |
| 4 | Хүн эмнэлгийн байранд засвар хийх | 2012 | Санхүүгийн эх үүсвэр олдоогүй |
| 5 | Сургуульд хүнсний стандартын шаардлага хангасан складтай болох | 2012 | 7,2 сая төгрөгөөр хүнсний складыг барьж ашиглаж байна |
| 6 | Малын гаралтай бүх төрлийн түүхий эдийг Монгол улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу борлуулах ажлыг зохион байгуулна. | 2012 | Тэмээ, хонины ноосыг нэгсэн журмаар төвлөрсөн цэгт нь тушаалгаж урамшуулалд 277,4 сая төгрөг олгов |
| 7 | Цахилгааны хүчдэлийн хүрэлцээ хангамжийг шийдвэрлэнэ | 2012 | 10кв-ийн шугам 500м, 0,4кв-ийн шугам 200м-ийг шинээр татаж трансформатор байрлуулснаар цахилгааны хүчдэлийн дутагдлыг бүрэн шийдвэрлэсэн |
| 8 | Сум орны үзэсгэлэнт газруудын зураглалаар альбом гаргах ажлыг дуусгана. | 2012 | Зураглал хийгдэж байгаа |
| 9 | Өвсний фондыг засварлаж ашиглалтанд оруулах | 2012 | Засварт 56,8 сая төгрөг төсөвлөгдсөн боловч ажил эхлээгүй байгаа |
| 10 | Сумын хөгжлийн хэтийн төлөвийн зураглалыг хийж дуусгах | 2012 | Зураглал хийгдэж байгаа |
| 11 | Сумын ойрын болон хэтийн хөгжлийн стратеги төлөвлөлтийг гаргаж батлуулах | 2012 | 2012 оны стратеги төлөвлөгөө хийгдэж байгаа |
| 12 | Жалханз хутагт Дамдинбазарын ажиллаж амьдарч байсан түүхэн газрыг хамгаалах тохижуулах ажлыг хийж аялал жуулчлалын газар болгох | 2012 | Байгууллага иргэдийн хандивын 20 –оод сая төгрөгөөр хөшөө цогцолборыг босголоо |
| 13 | Хүний эмчийн хүрэлцээг шийдвэрлэнэ /их эмч/ | 2012 | Завхан аймгаас 2 их эмчтэй 3 жилийн гэрээ байгуулан тодорхой урамшуулал олгож ажиллуулж байгаа. Мөн орон нутгийн ЭМШУИС-ийг төгсөж байгаа 1 оюутантай гэрээ байгуулж тухайн жилийн төлбөрийг УИХ-ийн гишүүн Л.Энх-Амгалангийн багцаас шийдвэрлүүлэв. Ингэснээр одоогийн байдлаар 3 их эмч ажиллаж байна. |
| 14 | Засаг даргын Тамгын газрын машиныг шинэчлэх | 2012 | Орон нутагт хайгуулийн лиценз бүхий АА-н нэгжүүдэд хүсэлт |

| | | | |
|---|---|---|---|
| | | | гаргаснаар санхүүгийн эх үүсвэрийг олж 20,0 сая төгрөгөөр шинэ машин авч үйлчилгээний машиныг шинэчиллээ. |
| 15 | Шаргын гол болон Цагаан нуурын голидорлогийг сэргээх | 2012 | Хөрөнгийн эх үүсвэр олдоогүй |
| 16 | Нэгдсэн хогийн цэгийг эмх цэгцэнд оруулах | 2012 | БОТХТ, СДЭ-тэй хамтарч 2 сая төгрөгөөр нэгдсэн хогийн цэгийг 40-50м дотогш хумьж түрээд 2 нэвт зам гаргасан |
| 17 | Сумын хүүхдийн тоглоомын нэгдсэн талбайг бий болгож тохижуулах | 2012 | УИХ-ын гишүүн Л.Гүндалайн багцаас нэгдсэн талбайг 22 сая төгрөгөөр байгуулсан |
| 18 | Конторын өргөтгөлийн засварыг ашиглалтанд оруулах | 2012 | Хөрөнгийн эх үүсвэр олдоогүй |
| 19 | Халуун усны байрыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн засварлаж тохижуулах | 2012 | Хөрөнгийн эх үүсвэр олдоогүй |
| 20 | Монгол мал хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлуудыг шийдвэрлэх | 2012 | Тухайн онд хийгдэх ажлыг шийдвэрлэж Тухайлбал: Адуунаас бусад 4-н төрлийн малд ивамекээс боловсоруулалтанд 256,0 мянган мал хамрагдсан. Бруцеллез өвчнөөс эмчлэх улс вакцинд бод 16943 толгой мал, бод мал 325211 толгой малд, бруцеллезын тандалт шинжилгээнд 14 өрхийн 392 толгой мал хамрагдаж 324,0 мянган төгрөгний зардалтай хийгдсэн |
| 21 | МАА-н түүхий эдийг биржээр дамжуулахын тулд загвар хоршоо нэгийг байгуулан ажиллуулах | 2012 | Загвар хоршоог байгуулах талаар эрх бүхий дээд байгууллагад хэлцэл хийсэн |
| 22 | Хүүхдийн цэцэрлэгийн байрны өргөтгөлийг шийдвэрлэх | 2012 | Хүүхдийн цэцэрлэгийн байрны өргөтгөлд 60 сая төгрөг төсөвлөгдсөн боловч халаалтын төв шугамыг солив |
| 23 | Хүн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2012 | Зарим тоног төхөөрөмжийг нийлүүлсэн |
| 24 | Гудамжны гэрэлтүүлгийн асуудлыг шийдвэрлэх | 2012 | 22 сая төгрөгөөр гэрэлтүүлгийг шийдвэрлэлээ |
| 25 | БО-ны ажилчдыг унаажуулах техник хэрэгслээр хангах | 2012 | 326000 төгрөгийн техник хэрэгсэл хувцасаар хангасан |
| 26 | Байгаль орчны нөхөн сэргээлтийг 2 га-д хийнэ | 2012 | ӨО-ы нөхөн сэргээлтийн ажилыг 4,5 га-д хийсэн |
| 27 | Хөнөөлт мэргэчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ | 2012 | Хөнөөлт мэргэчидтэй тэмцэх ажлыг 17,2 сая төгрөгийн санхүүжилтийг олж зохион байгуулсан |
| 28 | АҮ-ний ашиглалтыг сайжруулж Жижиг дунд үйлдвэрийг дэмжин орон байр, | 2012 | АҮ-ий байрыг засварлаж жижиг дунд үйлдвэрлэгчдэд |

| | | | |
|---|---|---|---|
| | тоног төхөөрөмжийн зээлд хамруулна | | түрээслүүлж ажиллуулсан тэдгээрт зориулж 93 сая төгрөгийн зээллэг олголоо |
| 29 | МЭ-ийн хоршоодуудын үйл ажиллагааг дэмжин ажлыг тогтмолжуулж хариуцлагыг дээшлүүлнэ | 2012 | Монгол мал хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж 8,4 ёая төгрөг хөрөнгө оруулалт хийгдсэн. Үйл ажиллагааг нь дэмжиж мал эмнэлгийн нэгдсэн хашаа ТА-2 төслийн санхүүжилтээр 5,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн |
| 30 | СӨБ-ын 140 метр урт халаалтын шугамыг солих | 2012 | СӨБ-д 150м-ийн халаалтын төв шугамыг солисон |
| 31 | Шинэ хороолол болон шаардлагатай газруудад усан сангууд байгуулах | 2012 | Шаардлагатай газруудыг товлож 2 усан сан барихаар хөрөнгийн асуудал болох 25 сая төгрөгийг шийдвэрлэлээ |
| 32 | Одонтой эхчүүдийн баяр тэмдэглэх | 2012 | Одонтой эхчүүдийн баярыг 3 сарын 8-д эмэгтэйчүүдийн зөвлөлөөс зохион байгуулах |

Тухайн онд сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 32 зорилт тавьснаас бүрэн хэрэгжсэн 23, хэрэгжих шатандаа 6, тасарсан 3 байна. Ингээд үндсэн чиглэлд тусгасан зорилтууд 90,6%-ийн биелэлттэй гарлаа. Энэ бол чамлахааргүй амжилт гэж бодож байна. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлсэнээр иргэдийн амьдрах орчин нөхцөлд тодорхой хувь нэмэр болсон гэдэгт итгэл дүүрэн байна. Тухайлбал: сумын халаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэснээс гадна цахилгааны хүчдэлийн дутагдлаас бүрэн ангижруулж чадсаныг тэмдэглэж хэлэхийг хүсч байна. Гэхдээ дээрх ажил үйлчилгээ хариуцан ажиллаж байгаа хүмүүсийн хариуцлага сул, ажилдаа өөриймсөг бус хандаж байгаагаас зарим байгууллагуудад халаалт дулааны асуудал шаардлагын түвшинд хүрч байсныг ч хүртэл зөвшөөрхөөс аргагүй гэж бодож байна. Нэгэнт хөрөнгө мөнгө хүч зарцуулан хийгдэж байгаа бүтээн байгуулалтаар боссон эд хөрөнгө байгууламжуудыг ариг гамтай байлгаж бидний юм миний төлөө орон нутгийн төлөө хийгдсэн юм гэдэг ойлголтоор хандаж байхыг нийт иргэдээсээ хүсмээр байна. Өнгөрсөн жил нэлээд том зорилтуудыг тусгаж хэрэгжүүлэхийг зорисон боловч хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэр олдоогүйгээс болон шат шатны сонгуулийн үйл ажиллагаа явагдаснаас болж улс орны хувьд төрийн бодлого тодорхой хэмжээнд алдагдсанаас шалтгаалж үндсэн чиглэлд тусгасан зарим зорилтууд тасархад хүрсэн юм.

# Цагаан-уул сумын нийгэм эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл:

| д/д | Хийгдэх ажилууд | Хугацаа | |
|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих 90-н хүүхдийн | 2013 | |
| 2 | Сумын орон нутгийн музейн барилга барих | 2013 | |
| 3 | Сумын төвд 2-3 ширхэг усан сан барих | 2013 | |
| 4 | Ус зөөврийн зориулалтын машин 15 тн-с доошгүй даацтай | | |
| 5 | Засаг даргын Тамгын газрын конторт их засвар хийх | 2013 | |
| 6 | Суман дахь цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | 2013 | |
| 7 | Үерийн ус зайлуулах суваг барих, төв замын зарим хэсгийг засварлана | 2013 | |
| 8 | Монгол Улсын 2 дахь Ерөнхий сайд Жалханз худагт Дамдинбазарын хөшөө цогцолборыг өргөтгөж ногоон байгууламжтай болгохоос гадна аялал жуулчидын сонирхлыг татахуйц үзмэртэй болгох | 2013 | |
| 9 | Ахуйн үйлчилгээний байрыг бүрэн эзэмшиж үйлдвэрлэл үйлчилгээг явуулдаг байх. Тоног төхөөрөмжөөр хангах | 2013 | |
| 10 | Сум дундын эмнэлгийн их засвар хийх | 2013 | |
| 11 | Хөдөлмөрийн кабинет ,дуу хөгжим хүүхдийн авъяас нээх төвтэй болох | 2013 | |
| 12 | Сумын спорт заалны цонхыг шинэчилж шилэн блок болгох | 2013 | |
| 13 | Сум дундын тэжээлийн фондыг засварлан ашиглах | 2013 | |
| 14 | Хадлангийн механикжсан салаатай болох | 2013 | |
| 15 | Сум дундын эмнэлгийн мэс засал, шүдний, төрөхийн багаж техник хэрэгслээр хангах | 2013 | |
| 16 | Цагдаагийн кобонтой болох | 2013 | |
| 17 | Сумын төвд хэрэглээний болон түлшний мод худалдаалах зах байгуулах | 2013 | |
| 18 | Сумын төвийн хорооллын хэсэгт шинээр халуун усны барилга барих | 2013 | |
| 19 | ЗДТГ-т 6-н машины граж барих | 2013 | |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | Тосон багийн 5-н толгойд гүн өрөмийн худаг барих | 2013 | |
| 21 | Хужирт багийн Таравжид гүн өрөмийн худаг гаргах | 2013 | |
| 22 | 6-р багийн төв барих | 2013 | |
| 23 | Эсгийн үйлдвэр ашиглалтанд оруулах | 2013 | |
| 24 | Тосон багт агаарын дамжуулах шугам татан ашиглах | 2013 | |
| 25 | Хорооллын хаягийг шинэчилж хийх | 2013 | |
| 26 | Худагийн барилгын засвар хийх | 2013 | |
| 27 | Иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан ЭМ-ийн кабинет ЕББДС | 2013 | |

Шинэ онд сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт болгон 22 асуудлыг та нөхдөөр хэлэлцүүллж байгуулахаар оруулж байна. Эдгээр зорилтуудыг дэвшүүлж тавихын тулд улс төрийн намууд, байгууллагууд, ард иргэдийн санал хүсэлтийг чөлөөтэй авч тусгасныг тэмдэглэж хэлье. Та нөхдөөс дээрх зорилтуудыг хэлэлцэж батлаж өгөхийг хичээнгүйлэн хүсье.

Ингээд сум орноо удирдах бодлогод та нөхдийн минь оюун ухаан мэргэн оновчтой байхын зэрэгцээ амьдрал чинь өөдрөг, ажил үйлс чинь ард түмнийхээ сэтгэлд хүрч байхын өлзийтэй сайхан ерөөлийг өргөн дэвшүүлье.

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2012-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**2012-12-14**

Зорилго: *Монгол Улсын засгийн газрын бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх* , орон нутагт төрийн чиг үүргийг ил тод чанар хүртээмжтэй хүргэж, иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлж, төрийн бодлогод иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхийг дайчлах замаар сумын нийгэм эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд оршино.

## *Нэг. Хүнээ дээдлэнэ*

### 1.1 Хүүхэд, залуучуудын талаар :

1.1.1. Шинэчлэлийн засгийн газраас хэрэгжүүлж байгаа хүүхдийн авъяасыг эрт нээн илрүүлэх, амьдрах ухаанд сургах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор технологийн кабинет, дуу хөгжмийн кабинет, сургуулийн номын сангийн барилгыг шинээр барьж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, мөн хөгжмийн зэмсэг, ном сурах бичгээр бүрэн хангана

1.1.2. Хүүхдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, төрөлх нутаг, түүх уламжлалаа хайрлах хүмүүжлийг олгох тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.

1.1.3. Жил бүр "Эрүүл Хүүхэд" аяныг зохион байгуулж эмчийн үзлэг, оношлогоо шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулж, эмчилж сувилна.

1.1.4. Сурагчдын дотуур байрны ая тухтай нөхцлийг сайжруулж, гэрийн нөхцөлд ойртуулна.

1.1.5. Хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнг өргөжүүлнэ.

1.1.6. Сургуулийн насны хүүхдийг бүрэн хамруулж сургууль завсардалтыг зогсооно.

1.1.7. Сургууль цэцэрлэгийн гадаад, дотоод орчныг тохижуулж хүүхдийн сурч боловсрох хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.8. Сургууль, цэцэрлэгийг интернетэд холбож, "Цахим сургууль-Цахим сургалт" хөтөлбөрт хамруулах, онлайн зайны сургалтанд хамрагдах нөхцөл бололцоог бий болгоно.

1.1.9. Зуны улиралд гэр цэцэрлэгүүдийг байнга ажиллуулна.

1.1.10. Сургуулийн биеийн тамирын задгай талбайг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулна.

1.1.11. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгана.

1.1.12. Аймгийн МСҮТ-д мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг иргэд аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч, ажил олгогчийн саналд үндэслэн зохион байгуулж, зайны, онлайн, шавь сургалтыг өргөжүүлнэ.

1.1.13. Их дээд сургууль төгсөгчдийг орон нутгийн шаарлагатай ажлын байранд зуучилж нутагтаа ирсэн залуус бүрийг ажилтай болгох асуудлыг дэс дараатай шийдвэрлэнэ.

1.1.14.Залуу багш, эмч мэргэжил, арга зүй, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн, орон сууц, нийгмийн асуудлыг шийдэх боломж бүхий хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалт зохион байгуулан ажиллах.

## 1.2. Ахмад настны талаар :

1.2.1.Сумын ахмадын холбоог байртай болгож ахмадуудын эмчилгээ сувилгаа, өдөр өнжүүлэх төвийг нээж , Ахмадуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, сэтгэл санааг дэмжиж байнгын ажиллагаатай болгоно.

1.2.2. 65- аас дээш насны ахмадуудыг эмчийн үзлэгт оруулах, хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг дараалал харгалзахгүйгээр үзүүлнэ.

1.2.3.Ахмадуудад бүх төрлийн төрийн үйлчилгээг дараалал харгалзахгүй үзүүлнэ.

1.2.4.Ахмадуудын нөхөрлөл, хоршоо байгуулан, хөдөлмөр эрхлэх асуудлыг бүх талаар дэмжинэ.

## 1.3. Иргэдийн эрүүл мэндийн талаар:

1.3.1.Сумын эмнэлэгийн их эмчийг хүрэлцээг шаардлагтай орон тоонд хүргэнэ.

1.3.2.Мэдээллийн технологийг эрчимтэй нэвтрүүлж цахим эмнэлэгийн сүлжээнд холбогдон эмч нарыг нарийн мэргэжлээр давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллгааг онлайн зайны сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

1.3.3.Оншилгооны тенхик хэрэгсэлийн хангамжийг сайжруулж халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх, онлайн зайны оншилгоог нэвтрүүлнэ.

1.3.4.Эмнэлэгийн түргэн тусламжийн үйлчилгээний 2 машиныг тус бүр жолоочоор хангана.

1.3.5.Хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны ажлыг шинэ арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулан явуулна. / Сургалтын танхимыг тохижуулах/

1.3.6.Олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх

1.3.7.Нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны эрүүл мэндийн үйл ажиллагаанд сайн дурын ажилтны оролцоог нэмэгдүүлэн дэмжиж тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

## 1.4 Эхчүүд, эмэгтэйчүүдийн талаар :

1.4.1.ТББ, ИНБ-уудын үйл ажиллагааг эхчүүд, эмэгтэйчүүдэд хандуулна.

1.4.2.Удирдах боловсон хүчин, төрийн албанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.4.3.Төсөл хөтөлбөрийн тодорхой хувийг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглүүлэх.

1.4.4.Эмэгтэйчүүдийг дэмжих ТББ, Мэргэжил сонирхлын бүлгийг төрөөс дэмжиж эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх.

1.4.5.Эмэгтэйчүүдийн хөгжил, суртгалтын төв байгуулна.

1.4.6.Өрх толгойсон эмэгтэйчүүдийн / эрэгтэйчүүдийн / нийгмийн хамгааллын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.4.7.Алслагдсан багт болон хүйтний улиралд эх, хүүхэд, эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

## 1.5. Ажилсаг иргэн- хариуцлагатай төр :

**1.5.1.** Иргэн төвтэй төрийн удирдагыг бий болгоно.

**1.5.2.** Хууль ёс дэг журмыг сахиж төрийн сахилгыг чангатгана

**1.5.3.** Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор "Хөдөлгөөнт" Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

**1.5.4.** Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хүнд сурталаас ангид, ил тод, нээлттэй болгож, иргэдэд тэгш, шударгаар үйлчилдэг, итгэл дэмжлэгийг хүлээсэн төрийн хариуцлагатай тогтолцоог бүрдүүлнэ.

**1.5.5.** Төрийн үйлчилгээнд нийтийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг тэргүүн ээлжинд хангахыг эрхэмлэж, аливаа шийдвэр гаргах явцад иргэдийн "Шууд оролцоо"-г хангаж ажиллана.

**1.5.6.** Төрийн албан хаагчдын үйлчилгээг иргэдээр үнэлүүлж, албан тушаалтанд хариуцлага тооцох тогтолцоог бий болгоно.

**1.5.7.** Төсвийн ил тод байдлыг хангаж сумын төсвийн байгууллагуудын төсвөөс гарсан нэг төгрөг бүрийн зарцуулалтыг иргэдэд мэдээлэх, тайлагнах ажлыг хэрэгжүүлнэ.

**1.5.8.** Газрыг ашиглах, эзэмших, өмчлөх харилцаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хяналт тавиулна.

1.5.9.Ажил орлогогүй өрх бүрийн нэг гишүүнийг мэргэшүүлэн, хөдөлмөр зуучлалын зохион байгуулалт хийж, ажилтай болгох талаар шийдвэр гаргана .

1.5.10.Улаанбаатар хотод нутгийн иргэддээ үйлчлэх мэдээлэл, жуучлалын төвийг Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран байгуулна.

1.5.11.Нэг цэгийн ахуйн үйлчилгээний төвийг бүрэн хэмжээгээр нь ажиллуулж аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд оруулна.

1.5.12.Монгол гэрийн хатуу зөөлөн эдлэл, орчин үеийн хийц загвартай өвөл зуны гутал болон бусад зөөлөн оёдлын хэрэгцээг сумынхаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангана.

1.5.13. "Архигүй Цагаан-Уул" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5.14.Ноос, ноолуур бэлтгэхэд урамшуулал олгодог ажлыг үргэжлүүлэн шинээр арьс, шир, мах сүүнд урамшуулал олгуулах ажлыг шийдвэрлүүлнэ.

1.5.15.Хадлан тэжээл бэлтгэх ажлыг хөнгөвчлөх, сайжруулах зорилгоор малчин өрхөд хадлангийн багаж, техник хэрэгсэлийн хангамжийг сайжруулах, сумын хадлан тэжээлийн нөөцийг бэлтгэх хадлангийн салаа байгуулна.

1.5.16."Малчин" мэргэжил олгох сургалт зохион байгуулах, "Малчдын зөвлөлгөөн", "Төлчдийн семинар", " Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн", "Үйлдвэрлэгчдийн зөвлөгөөн"-үүдийг жил бүр хийх.

1.5.17.Малын өвөлжөөг шинэчлэхэд онцгой анхаарч, шаардлагатай мод бэлтгэх зөвшөөрлийг олгоно.

1.5.18.Өрхийн газар тариалан эрхлэгчдийг бүх талаар дэмжиж, механикжуулах арга хэмжээ авна.

1.5.19.Газар тариалангийн үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлтэй зээл олгуулах асуудлыг шийдвэрлүүлнэ.

1.5.20.Сумын иргэдийн санал бодлыг сонсох, өргөдөл гомдол хүлээж авах байнгын утас ажиллуулна.

1.5.21.Сумын ЗДТГ-т иргэдэд нээлттэй харилцах зорилгоор иргэний танхим байгуулж иргэдийг хүлээн авах, тэдний санал хүсэлтийг сонсож, гарах шийдвэрт тусгаж биелэлтийг иргэдэд тайлагнана.

1.5.22. "Цагаан-Уулд үйлдвэрлэв" брэнд бүтээгдэхүүний дэлгүүрийг Мөрөн хотод нээж ажиллуулна.

1.5.23. Сумын төвд багуудаас ирсэн малын гаралтай бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ дэлгүүр байгуулах.

1.5.24. Хөдөөгийн иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанар , хүртээмж, давтамжийг нэмэгдүүлэх, зайны болон нүүдлийн үйлчилгээг тогтмолжуулна.

1.5.25. Гэр бүл, өрх рүү чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын цогц үйл ажиллагаа явуулдаг "Гэр бүлийн хөгжлийн төв"-ийг байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

1.5.26. Олон хүүхэдтэй айл, өрхийг бүх талаар дэмжиж хүний эрхэнд суурилсан гэр бүл төвтэй цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5.27. Иргэний нийгмийн байгууллагатай хамтран зорилтот бүлгийг тодорхойлж, тэднийг нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулах.

1.5.28. Өрх бүрийг тогтвортой ажлын байртай, байнгын орлоготой болгох замаар ядуурал, ажилгүйдлийг түвшинг бууруулах цогц арга хэмжээг авч, иргэдийнхээ амьдрал ахуйд томоохон өөрчлөлт хийхийг зорино.

1.5.29. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлж, зээлийн хүртээмжийг сайжруулснаар Өрхийн аж ахуй эрхлэх, хоршоо нөхөрлөл байгуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

1.5.30. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээг нэвтрүүлнэ.

## ***Хоёр: Эдийн засгийн эрчимтэй хөгжил- Бүтээн байгуулалт:***

2.1.1."Бүтээн байгуулалт бүр миний төлөө" гэсэн сэтгэлгээний хандлагыг иргэн бүрт төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

2.1.2.Төвийн доторх замыг дэс дараатай засварлаж, зарим төв хэсгийн гудамжид хатуу хучилттай авто зам барина.

2.1.3.Сумын төвөөс аймаг хүртлэх замыг сайжруулж, засварлана.

2.1.4.Сумын төвийн шинээр баригдаж байгаа хорооллуудыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.

5.1.5.Шахмал түлшний үйлдвэр байгуулж айл өрхөд хямд төсөр өртгөөр түлш нийлүүлэх санаачлагыг дэмжиж ажиллана.

2.1.6. Төв зам дагуу Төвлөрсөн багийг эрчим хүчээр хангаж, хэрэгцээтэй үйлчилгээний газруудыг бий болгоно.

2.1.7. Сумын хүн ам ихээр төвлөрч байгаа гудамж хороололд Хүүхдийн цэцэрлэг шинээр барина

2.1.8. Шилэн кабелийг бүрэн хэмжээгээр холбож интернет болон мэдээллийн технологийг эрчимтэй нэвтрүүлнэ.

2.1.9. Бүх багийг үүрэн телефоны оператортай болгоно.

2.1.10. Сумын 2016 он хүртэлхи ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.1.11. Багшийн хөгжлийг дэмжих багш, суралцагчдад зориулсан зуны сургалтыг тогтмолжуулна.

2.1.12. Сум дундын эмнэлэгийн барилгын их засварыг хийлгэх улмаар шинээр эмнэлэгийн барилга барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ.

2.1.13. Соёлын төвийн материаллаг баазыг сайжруулж, соёлын ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.

2.1.14. Сумын соёлын төвийг үндэсний хөгжмөөр хангаж, үндэсний соёл, уламжлалт зан заншлыг хадгалан хамгаалах, сурталчлан дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.

2.1.15. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж татварын шинэчлэлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлж бизнесийн таатай орчинг бүрдүүлнэ.

2.1.16. Төсөв санхүү худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг иргэд, олон нийтийн хяналтан дор ил тод явуулна.

2.1.17. Төсвийн шинэчлэлийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж төсвийн захиран зарцуулалтын хариуцлагыг өндөржүүлнэ.

2.1.18. Барилгын материалын, малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулах санаачлагыг дэмжинэ.

2.1.19. Түүхийн соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, суртчилах, сэргээн босгох ажлыг зохион байгуулна.

2.1.20. Сумын орон нутгийн Музейн барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулна.

2.1.21. Шинэ хорооллуудад 2-3 ширхэг усан сан барьж ашиглалтанд оруулна.

2.1.22. Ус зөөврийн зориулалтай 15 тонноос доошгүй даац бүхий машинтай болгоно.

2.1.23. Засаг даргын Тамгын газрын конторт их засвар хийнэ.

2.1.24. Хүүхдийн ордон байгуулна / 2013-2014 онд /

2.1.25. Сум дундын эмнэлэгийн өргөтгөл барина. / 2014 онд/

2.1.26. Шинээр 100 хүүхдийн цэцэрлэг барина. / 2013-2014 онд /

2.1.27. Суман дахь цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөж, ногоон байгууламж нэмэгдүүлэн гадна дотны аялал жуулчидын сонирхлыг татахуйц хэмжээнд тохижуулна.

2.1.28. Мах боловсруулах үйлдвэр байгуулж ашиглалтанд оруулна.

2.1.29. Монгол Улсын 2 дахь Ерөнхий сайд асан Жалханз хутагт Дамдинбазарын хөшөө цогцолборыг өргөтгөж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн аялал жуулчлалын сонирхлыг татахуйц тохижилт хийнэ.

2.1.30. Хуучин нэгдлийн суурийг ашиглаж, жижиг дунд үйлдвэр байгуулж, жишиг хоршоо болгоно.

2.1.31. Сумын спорт заалны цонхыг вакумжуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

2.1.32. Суманд спорт цогцолбортой болно. .

2.1.33. 440 хүүхдийн хичээлийн байрны шал, тээврийг солино.

2.1.34. Сургуульд чийрэгжүүлэх танхимыг тоног төхөөрөмжөөр хангана.

2.1.35. Сургуулийн хатуу эдлэл, ширээ сандлыг шинэчилнэ.

2.1.36. Дотуур байрны хүүхдийн орны солилтыг 100 хувь хийнэ.

2.1.37. Ноос угаах үйлдвэр барьж байгуулна.

2.1.38. Сум дундын тэжээлийн фондыг засварлаж ашиглалтанд оруулна.

2.1.39. Сум дундын эмнэлэгт шаардлагатай багаж, техник хэрэгслээр хангана.

2.1.40. Цагдаагийн хэсэгтэй болж, цагдаагийн кабон барьж ашиглалтанд оруулна.

2.1.41. Сумын төвд хэрэглээний болон түлшний мод худалдах зах байгуулна.

2.1.42. Сумын төвийн хороололын хэсэгт шинээр халуун усны барилга барьж ашиглалтанд оруулна.

2.1.43. Засаг даргын Тамгын газарт 6 машины граж барьж ашиглана.

2.1.44. 6 дугаар багийн төвийг шинээр барьж ашиглалтанд оруулна.

2.1.45. Сум дундын эмнэлэг, Хүүхдийн цэцэрлэг, сургуульд бохир усны шугам татах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.

2.1.46. Сум дундын эмнэлэгт машины дулаан граж нэгийг шинээр барина.

2.1.47. Сумын төвийн үйлчилгээний гол цэгт камер тавина.

2.1.48. Бохирын усны машинтай болно.

2.1.49. Байгууллагуудын хүнсний болон ногооны зоорьтой болгоно.

2.1.50. Багийн төвүүдийг тохижуулж, багийн хариуцлагатнуудыг багийн төвд нь байнга суурьшуулна.

2.1.51. Мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, гэрийн модон эдлэлийн цехүүдийг дэмжин ажиллуулна.

2.1.52. Байгууллагуудыг галын багаж төхөөрөмжөөр бүрэн хангах.

**Гурав. Эрчимжсэн ХАА –Хөдөөгийн хөгжил :**

3.1.1. Малын чанар, үржлийн ажил үйлчилгээг хувийн хэвшлийн мал эмнэлэг, үржлийн нэгжүүдэд хариуцуулахаас гадна төрийн хяналтыг тогтмолжуулна.

3.1.2. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж баг бүрт 3-аас доошгүй инженерийн болон гар хийцний худаг гаргана.

3.1.3. Худаг засвар үйлчилгээ эрхлэх явуулын засварын бригадыг байгуулж дэмжлэг үзүүлнэ.

3.1.4. Өвс тэжээлийн нөөцийн цэгүүдийг улсын нөөцийн мэдэлд төвлөрүүлэн орон нутгаас нөөц бүрдүүлэх тэжээлийн ургамал тариалах, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ.

3.1.5. Мал сүргийг эрүүлжүүлж, гадаад зах зээлийг нээж улмаар малчдын малаас авах орлогыг нэмэгдүүлнэ.

3.1.6. Мал эмнэлгийн лаборторийг явуулын тоноглогдсон техник тоног төхөөрөмжөөр хангана.

3.1.7. Малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх замаар тэжээлийн хангамжийг сайжруулна.

3.1.8. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сүү цагаан идээ боловсруулах дунд оврын техник тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авна.

3.1.9. Баг бүрт загвар хоршоо бий болгон, малын гаралтай түүхий эд бэлтгэх боловсруулалт хийх аж ахуйн нэгж, цех үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.1.10. Малын гаралтай түүхий эд бэлтгэлийн цэгийг суманд бий болгоно.

3.1.11. Талх нарийн боовны жижиг үйлдвэр, цехүүдийн үйл ажиллагааг дэмжиж сумынхаа хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүргэнэ

3.1.12. Тэмээний тоо толгойг өсгөх талаар урамшуулалын механизмийг хэрэглэх.

3.1.13. Мал аж ахуйд шаардлагатай боловсон хүчнээр хангах асуудлыг бодлогоор шийдвэрлэнэ.

3.1.14. Мал эмнэлэгийн ариутгалын машинтай болох.

3.1.15. Зах хязгаарын нутгийг бүрэн дүүрэн ашиглахад эдийн засгийн урамшууллын механизмийг хэрэглэх.

## Дөрөв. Иргэддээ итгэсэн байгаль хамгаалал :

4.1.1. Байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцаж байгаа багийн Засаг даргын үүрэг хариуцлагыг эрс өндөржүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээг бодлогын түвшинд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.2. Сумын байгаль орчныг хамгаалах чиглэлийн байгууллагуудын хамтын ажиллагааны менежментийг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ

4.1.3. Сумын байгаль орчны тогтвортой хөгжийн бодлогын тасгийн байгаль хамгаалагчийн орон тоог нэмэгдүүлэх тэднийг чадавхижуулж шаардлагатай техник хэрэгсэлээр хангаж, санхүүгийн нөөц бололцоог нэмэгдүүлнэ.

4.1.4. Ой, ан амьтан, байгалийн ургамал хамгаалах , зохистой ашиглах ажлыг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл байгуулах замаар шийдвэрлэхэд түлхүү анхаарах.

4.1.5. Идэвхтэн байгаль хамгаалагчдын оновчтой сүлжээ зохион байгуулж , тэднийг байнгын удирдлагаар хангаж, урамшууллын механизмыг хэрэглэж зөрчлийн хэмжээг бууруулах.

4.1.6. Сумын байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан байгуулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангахаас гадна бодлого боловсруулах, байгаль орчны төлөв байдал, өөрчлөлт зэрэгт хяналт тавихад үр бүтээлтэй ашиглах.

4.1.7. Байгаль орчны эсрэг гэмт, хэрэг зөрчлийг илрүүлж мэдээлж, шийдвэрлүүлсэн болон орчноо цэцэрлэгжүүлж, ногоон орчин бүрдүүлсэн иргэн, ААНБ-ыг урамшуулах журам боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.

4.1.8. Сумын нутаг дээрх усны нөөцийг хамгаалах, түүний бүрэлдэн тогтох, цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх бүхий л боломжийг хангах бодлогын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

4.1.9. Нутаг дэвсгэртээ усны нөөц чанарын хяналтыг ус судлалын харуулуудаар болон жижиг лабораториар дамжуулан гүйцэтгэх, шуурхай байдлыг хангах .

4.1.10. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах журам батлуулан, хэрэгжилтийг хангаж “Хоггүй сум” болох зорилт тавина.

4.1.11. Ногоон гудамж, хороолол, сургууль, байгууллага зэрэг Ногоон шалгуураар үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог нэвтрүүлнэ.

4.1.12. Сумын ойн санг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг нутгийн иргэд, төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

4.1.13. Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих замаар ойн санг хамгаална.

4.1.14. Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудтай хамтран сайжруулна.

4.1.15. Иргэдийн ойн санг хамгаалах ухамсарыг дээшлүүлэх зорилгоор сургалт, сурталчилгааг төрийн бус байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулана.

4.1.16. Улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулна.

4.1.17. Өөрсдийн амьдрах орчиныг сайжруулах зорилгоор төрөл бүрийн мод бут тарьж буй үйл ажиллагааг дэмжиж урамшууллын механизмийг бий болгоно

4.1.18. Жил бүрийн хавар, намар бүр "Танайд мод тарья "аяныг зохион байгуулж таны тарих гэж буй модыг үнэгүй тарьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлнэ.

4.1.19. Ойгоос мод бэлтгэж, ашиглах ажлыг ойн нөөц, даацад нь тааруулан мэргэжлийн түвшинд системтэйгээр сайжруулж, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсооно.

4.1.20. Тухайн баг, байгууллагын жилд бэлтгэх модны тоо, сумаас гадагш гаргах модны хэмжээг иргэдийн оролцоотойгоор багийн ИНХ, сумын иргэдийн хурлаар хэлэлцэн батлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтыг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх,

4.1.21. Сумын хэмжээнд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах ажил, ойд арчилгааны огтлолт хийх, ойн хортон, шавжтай тэмцэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зэрэг ажлын зардлыг аймаг, сумын орон нутгийн төсөвт тусган гүйцэтгэж, ажлын явцын хяналт, гүйцэтгэлийн аудит хийлгэж ажиллана,

4.1.22. Мод бэлтгэлийг зөвхөн тусгаарласан талбайгаас хийлгэх

4.1.23. Шаргын гол Цагааннуурын гольдорлогыг сэргээж нуурын эргэн тойрон ногоон байгууламж бий болгоно.

## Тав. Аялал жуучлалыг хөгжүүлэх талаар :

5.1.1. Гадаадын жуулчин, дотоодын аялагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан "Отоглох цэг " бий болгож, мөрдөх журмыг батлуулна.

5.1.2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын хамгаалалт, зохистой ашиглалтын менежментийг сайжруулж эко аялал жуулчлалыг зохион байгуулах отог, маршрутыг бий болгоно

5.1.3. Суманд гадаадын жуулчин, дотоодын аялагчдад зориулсан мэдээллийн төв, гар урлалын худалдаа, бусад үйлчилгээг үзүүлэх санаачлагыг дэмжинэ .

## Зургаа . Амар тайван иргэдтэй аюулгүй Сум :

6.1.1. Иргэдийн ажиллаж амьдрах, сурч боловсрох орчныг амар тайван аюулгүй байдалд нийцүүлж, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлсэд төрийн бүх байгууллага, иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлнэ.

6.1.2. Орон нутгийг цагдаагийн кобан системд шилжүүлэх ажлыг эрчимжүүлэн сумыг цагдаагийн хэсгийг кобантай болгож, албан хаагчийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.

6.1.3. Малын хулгай, насанд хүрээгүй хүмүүс холбогдсон болон байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.

6.1.4. Хууль зүйн сургалт, сурталчилгааг чанарын шинэ шатанд гаргаж, иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлнэ.

6.1.5. Архидан согтуурах явдлын эсрэг олон талын арга хэмжээг авч энэ талаар иргэд, иргэний нийгмийн байгууллагын санаачлагыг дэмжин ажиллана.